

## МАХН-ЫН VII ИХ ХУРАЛД Ж.ЦЭВЭЭНИЙ ХЭЛСЭН ҮГИЙН ТУХАЙД

Ч.Болдбаатар

Монгол Улсын Боловсролын Их Сургууль. Түүх, Нийгмийн ухааны сургууль.

**Өгүүллийн товч утга:** Энэ өгүүлэлд Монголын төр нийгмийн нэрт зүтгэлтэн Жамсраны Цэвээн МАХН-ын VII их хуралд үг хэлсэн эсэх, ямар агуулгатай санал шүүмжлэл тавьсаныг судлан үзсэн болно.

**Түлхүүр үг:** МАХН, VII их хурал, Цэвээн, үндэсний үзэл, шашин.

1928 онд хуралдсан МАХН-ын VII их хурлаар зүүний бүлгийнхэн Коминтерний тусламж дэмжлэгтэйгээр Монголын үндэсний ардчилсан үзэлтнүүдийг "баруунтан" хэмээн буруутган албан тушаалаас нь зайлуулсан билээ. "Баруунтан" бологсдын гол хүн болох Ж.Цэвээн тус их хурал дээр үг хэлсэн эсэх, ямар утгатай үг хэлж санал шүүмжлэл тавьсан нь сонирхол татсан асуудал хэвээр байна. МАХН-ын VII их хурал дээр "Ж.Цэвээн шүүмжлэл тавьсан нь тодорхой боловч тэрхүү шүүмжлэл хэвлэмэл болон архивын материалаас энэ хир олдохгүй байна"<sup>1</sup> хэмээн Д.Даш аругай тэмдэглэжээ. Үнэхээр намын VII их хурлын баримт бичигт Ж.Цэвээний хэлсэн үг, тавьсан санал шүүмжлэл огт байхгүй бөгөөд улстөрийн зорилгоор эсэргүү болсон түүний үгийг хасаж хэвлэсэн нь бүхэнд илэрхий. Хурал дээр төлөөлөгчдийн санал шүүмжлэлийг чөлөөтэй өрнүүлж нийт 196 хүн байр сууриа илэрхийлсэн бөгөөд тус хурлын дэлгэрэнгүй материалыг 1929 онд 11 дэвтрээр хэвлэн гаргажээ. Намын VII их хурал дээр Ж.Цэвээн үг хэлсэн нь хэд хэдэн баримтаар нотлогдож байна. Үүнд:

- 1928 оны аравдугаар сарын 26-нд БНМАУ дахь ЗСБНХУ-ын Бүрэн эрхт төлөөлөгч А.Я.Охтинос ЗХУ-ын ГХАК-т явуулсан "МАХН-ын VII их хурлын санал шүүмжлэлийн шинж чанарын тухай болон Намын Төв Хороо ба БНМАУ-ын Засгийн газрын удирдах албанд дэвшүүлэх хүмүүсийн тухай" маш нууцын зэрэглэлтэй цахилгаан утсанд "Их хурал дээр санал шүүмжлэл 14 хоног үргэлжилж хуучин удирдлага, Засгийн газрын үйл ажиллагаа, Төв Хороог ялангуяа хөдөөний төлөөлөгчдийн зүгээс эрс бөгөөд буурьтай шүүмжилсэн шинж чанартай байна.Тухайлбал Жамсраног үг хэлэх гэхэд төлөөлөгчид саатуулан удтал үг хэлүүлэхгүй байв"<sup>2</sup> гэж бичжээ.

- Их хурлын төлөөлөгчдийн санал шүүмжлэлд "Цэвээний шүүмжлэлд хариу эсэргүүцэх нь"<sup>3</sup> гэх зэргээр тэмдэглэгдсэнээс үзэхэд тэрбээр үг хэлсэн нь магадтай хэрэг ажээ.

- Түүнчлэн Ж.Цэвээнээс 1931 оны наймдугаар сард Намын Төв Хороонд гэж хаяглан гаргасан өргөдөл бичигтээ "Ийнхүү газар тариалангийн ажил эрхлэн суугч монголчуудыг олон түмээр ирүүлбээс ...соёл боловсролын сайн нөхцөл бүрэлдэх асан билээ" гээд ард нь "Намын Төв Хороо,Төв Шалган Байцаах Комиссын хавсарсан бүгд хурал ба Намын VII их хуралд миний гаргасан санал"<sup>4</sup> хэмээн тэмдэглэсэн байна.

Дээрхи баримтуудаас үзэхэд Ж.Цэвээн МАХН-ын Төв Шалган Байцаах Комиссын тэргүүлэгч гишүүний хувиар намын VII их хурал дээр өөрийн санал шүүмжлэлээ тавьсан нь харагдаж байна. Тэгвээс Ж.Цэвээн тус хурал дээр ямар агуулгатай санал шүүмжлэл өрнүүлсэн бэ? гэдэг асуудал зүй ёсоор урган гарч ирж байна. Ж.Цэвээний язгуурын суртал, үзэл хандлага, байр суурь, 1931 оны Намын Төв Хороонд гаргасан өргөдөл болон Их хурлын төлөөлөгчдөөс

<sup>1</sup> МАХН-ын VII их хурал. баримт бичиг, материалууд. УБ., 1980. х456

<sup>2</sup> Коминтерн ба Монгол. Баримтын эмхтгэл. УБ., 1996. баримт 57. х244

<sup>3</sup> МАХН-ын VII их хурал.баримт бичиг, материалууд. УБ., 1980. х185

<sup>4</sup> Жамсраны Цэвээн. Түүвэр зохиолууд УБ., 1997. х 37

Цэвээний шүүмжлэлд хариу болгон хэлсэн үгнээс түүний намын VII их хурал дээр хэлсэн үгийн утга санааг тоймлон гаргаж болмоор байна.

Ж.Цэвээн бол нэртэй эрдэмтэн, соён гэгээрүүлэгч байсны хувьд үнэн зөв хэмээсэн үзлээсээ ухарч мятрах нэгэн биш байсан бөгөөд үүнийгээ намын их хурлын өмнө хуралдсан Төв Хорооны III бүгд хурал дээр батлан харуулж "би бага наснаас үндэс язгуурыг хамгаалах бодлоготой бөгөөд энэхүү бодлогыг нэгэн цагаар орхиж чадахгүй байтугай нэгэн насаар орхиход бэрхтэй зүйл нь аливаа хүн төрөлхтний дотор язгуурын авъяасыг нэгэн цагаар халж болдоггүй зүйл буй"<sup>1</sup> хэмээсэн байдаг.

МАХН-ын VII их хуралд Ж.Цэвээний хэлсэн үгэнд хариу шүүмжлэл болгож 10 гаруй хүн үг хэлжээ. Тэдгээрээс ихэнх нь КУТВ-ийнхэн (З.Шижээ, Д.Чимид, Б.Элдэв-Очир зэрэг) байгаа нь Коминтерний баг "барууны үзэл сурталч"-ийг шүүмжлэх үүргийг шинэ залуу кадруудад хуваарилсан мэт дүр зураг харагдана. "Хөдөө"-гийн бүлгийнхний дайралт, шахалт, шүүмжлэлийн өнгө аяс нь Ж.Цэвээн намын их хурал дээр үндсэн хоёр асуудлаар үзэл бодлоо хамгаалж үг хэлснийг харуулж байна.

*Нэгд, Монгол үндэстнийг нэгтгэх тухай.* Цэвээн абугай насан туршид Монгол овогтныг нэгтгэсэн нэгэн их айл улс буй болгохын төлөөнөө эрмэлзэн зүдэж явсан агаад "СССР, Хятад хоёроос баталсан бөгөөд бусад олон улсаас бусад олон улсаас зөвшөөрөн хүлээсэн төвийг сахих улс болох хэрэгтэй...үндэсний хувьсгалын хөгжихийн хамт алжим алжмаар Монгол Ард Улсыг тойрон Монгол овогтны нэгэн холбоо байгуулж болно"<sup>2</sup> гэж үзэж байсан юм.

Түүний энэ үзлийг их хурал дээр Ө.Бадрах, Д.Чимид нарын хэд хэдэн хүн буруушаан шүүмжилжээ. Тухайлбал "...энэ хуралд Монгол үндэстнийг нэгтгэнэ гэж баатарлан хэлж буй...түүний хэлсэн үгийг зүв зүгээр өнгөрүүлж чадахгүй, эрхбиш хариулж эсэргүүцнэ. Монгол үндэстнийг нэгтгэхдээ хувьсгалын ёсоор нэгтгэнэ хэмээн гоёмсоглон хэлж буй... Цэвээн авгайн хэлдгээр (Өвөр Монголын Ч.Б) наад талыг нь таслаад цаад захыг орхиж нэгтгэнэ хэмээсэн нь үнэндээ үндэсний явцуу үзэл мөн<sup>3</sup> .../Д.Чимид- Ч.Б /, ...н.Жамсрановоос шүүмжилсний дотор Монгол угсаатныг нэгтгэнэ хэмээх үзэл нь гагцхүү одоо бус, хэзээнээс үргэлжлэн агуулж ирсэн. Үүнийг н.Чимидээс тайлбарлан шүүмжилсэн нь зүйтэй тул зөвшөөрч ... далдуураар явуулгыг үйлдэж язгуур угсааг нэгтгэнэ гэх зэргээр өгүүлбэл эрхбиш олон төлөөлөгчдийн толгойг эргүүлэхийг эрмэлзсэн бодлого даруй мөн болов уу..<sup>4</sup> /З.Шижээ-Ч.Б/, Цэвээнжамсрановаас манай Монгол улс болбаас бүх монгол овогтонтой нэгдвээс сая хүчин төгөлдөр хэмээн шүүмжлэн хэлж байсан<sup>5</sup> /Мижиддорж-Ч.Б/, Энэ өвгөн чөтгөрийн хорт суртлын заримыг өгүүлбэл: Монгол үндэстнийг нэгтгэх үзлээ баримталж хувьсгалт замаар монгол үндэстэн үндэс соёлоо нэгтгэн бадруулна хэмээн үзэж буй<sup>6</sup> /Ө.Бадрах-Ч.Б/ хэмээн дайрч давшилсан байна.

*Хоёрт, Шашныг дотночилон ариунаар мандуулах тухай.* Ж.Цэвээн шашны үзэлд шүүмжлэлтэйгээр хандаж мандуулах зорилт бодлогыг дэвшүүлэн тавьжээ. Тэрбээр "ХЗЭ ба Буддын шашин" өгүүлэлдээ "... бурхны сургаал нь хамгийн нарийн учир шалтгааныг үндсээр нь шинжлэн, үнэн зөвийг олсон нь машгүй, элдэвчлэн шинжилбэл шалгадаг ухаанд үл харшлан нийлэх тул үнэхээр дотночилон ... шашны хэргийг шүүмжлэхдээ буруу зөвийг ялган чадах болбоос

<sup>1</sup> МАХН-ын VII их хурал.баримт бичиг, материалууд. УБ., 1980. х 456

<sup>2</sup> Жамсраны Цэвээн. Түүвэр зохиолууд УБ., 1997. х 36-37

<sup>3</sup> МАХН-ын VII их хурал.баримт бичиг, материалууд. УБ., 1980. х 185

<sup>4</sup> Мөн тэнд. х 229

<sup>5</sup> Мөн тэнд. х 291

<sup>6</sup> Мөн тэнд. х 329

сайн"<sup>11</sup> хэмээн үзжээ Тэрбээр БНМАУ-д нийгэм журмын байгууллыг байгуулахдаа ангийн тэмцээн, ялгарлыг хурцатгалгүй нэгдмэл байлгаж үндэсний эв зөийг сахих нь чухал хэмээн үзэж байсан юм. Түүний энэхүү байр суурийг зүүний хэт хувьсгалчид элдэвчлэн муулж, буруутган доромжилж байсан нь намын хурлын дэлгэрэнгүй тайлангаас тодорхой харагддаг. Тухайлбал "Монголын хуучин түүх хэмээн үнэн худал олон зүйл номлон, түүгээрээ далимдуулан шарын шашны үзэл суртлыг дэлгэрүүлэн бататгахыг гол зорилго, лоозон болгоно. Гадуур өнгөн дээрээ энэхүү байдлуудыг тус Монголын хорт дайсан хэмээн чалчиж, хувьсгалч дүрээр олныг хууран мэхлэнэ!<sup>1</sup>/Ө.Бадрах-Ч.Б/, ...энэ мэтээр Буддын балар суртлыг Марксын суртал лугаа тэрслүүлэн Монголын ядуу ба дунд ардыг дахин гал усны гашуун аюулд оруулах гэсэн хортой бодлого болов уу гэж санана<sup>2</sup> /З.Шижээ-Ч.Б/, ...Жамсранов бол Монголын дотор хутагт хувилгаадтай нэг ч харилцаагүй хүн байхгүй бөгөөтөл одоо намын их хурал дээр бид эсэргүүцэх ёстой хэмээн хашгирч буй нь ямар жигтэй<sup>3</sup> /Б.Эл дэв-Очир-Ч.Б/, Шашны хувраг лам нарын тухай Жамсрановын саналыг шууд эсэргүүцнэ. Шашны тухай нэгэнт тогтоосон дотночилон үзнэ хэмээх тогтоолоо одоо буцаах хэрэггүй, багийг өмсөж дахин солих зэргээр олныг дахин дахин мэхлэх хэрэггүй хэмээжээ... үндсэн бодлого нь 11-р онд намын нэгдүгээр хурлаар тогтоосон эрмэлзэх 10 зүйлийн дотор дурдсан ёсоор шарын шашныг мандуулсугай хэмээсэн үндсэн утгыг эдүгээ хэрэг дээр нь гүйцэтгэхийг хүсэж явуулсаар явдаг нь илэрхий.<sup>4</sup>/Д.Чимид-Ч.Б/ гэх зэргээр түүнийг шүүмжилжээ.

Энэ бүхнээс үзэхэд намын VII их хурал дээр Ж.Цэвээн Монгол үндэстнийг нэгтгэх, шашныг ариунаар мандуулах тухай зарчмын шинжтэй үг хэлсэн нь тодорхой байна.

Тэр ч байтугай түүнийг үзэл суртлын хувьд буруутган "дарж" авах гэж оролдсны сацуу "Жамсранов гэх урт хошуутай, урт чихтэй нэг амьтан буй", "хувьсгалын чөтгөр, хувхай толгойт, хожуулан цогцот" зэргээр хүний ёсноос гадуур доромжилж гүтгэсэн байна.

**Abstract:** During the VII Great Khural (meeting) by the Mongolian Peoples' Revolutionary Party (MPRP), J.Tseveen appeared whose speech was principally emphasized on unification for the Mongol Nation and resounding Buddhist sacred religion.

<sup>11</sup> Жамсраны Цэвээн. Түүвэр зохиолууд УБ., 1997. х8

<sup>1</sup> Мөн тэнд. х 329

<sup>2</sup> Мөн тэнд. х 230

<sup>3</sup> Мөн тэнд. х 212

<sup>4</sup> Мөн тэнд. х 187